



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаа, үр дүн



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙГ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАН БОРЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨЖ БҮЙ ХУУЛЬ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ, АИТХ-ААР ХЭЛЭЛЦҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2018 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар3
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа	БҮЛЭГ 1. Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаанд мөрдөж буй хууль, журмын хэрэгжилт хангалтгүй, үр дүнг тооцож ажиллаагүй, холбогдох дүн шинжилгээ хийгээгүй байна.
Аудитын менежер Г.Наранбаяр	1.1. Дуудлага худалдааг зохион байгуулахад мөрдөж буй хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байна.
Ахлах аудитор Ц.Батсайхан	1.2. Дуудлага худалдааны ялагчтай эрх зүйн чадамжгүй гэрээ байгуулсан бөгөөд дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааны үр дүнг тооцож ажиллаагүй, холбогдох дүн шинжилгээ хийгээгүй байна.
Аудитор Б.Анхтуяа	
2018 оны 08 дугаар сар	БҮЛЭГ 2. Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаанд хяналт шалгалт огт хийгдээгүй байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151, 7054-3156, 7054-3179 дугаарын утсаар харилцана уу.	2.1 Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод мэдээлэх үйл явц өргөн цар хүрээг хамраагүй байна.
ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 208 тоот	2.2 Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаанд аймгийн ИТХ болон бусад байгууллагуудаас хяналт шалгалт огт хийгдээгүй байна.
	Дүгнэлт
	Зөвлөмж

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудитор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилго, зорилт

Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаа, үр дүнд Нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ. Үүнд:

1. Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаа хууль журмын хүрээнд зохион байгуулагдсан эсэх
2. Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаанд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад 2015-2017 оны Орон нутгийн өмчийн хөрөнгийн дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааг хамруулсан ба аймгийн Орон нутгийн өмчийн газар болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн дуудлага худалдааны үйл ажиллагаатай холбоотой анхан шатны баримт материал, мэдээ тайлан, судалгаанд тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын журам, АДБОУС 100, 400, 4100 стандартууд, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ, аудитын судалгаа хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нар гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Аудитад учирсан хүндрэл, бэрхшээл

Хүндрэл бэрхшээл гараагүй болно.

8. Үндсэн мэдээлэл

Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааг холбогдох хууль, журамд зааснаар хөрөнгийг эзэмшигч байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн АИТХ-аас худалдах шийдвэр гарснаар аймгийн ОНӨГ-аас зохион байгуулж ирсэн байна.

2015 онд аймгийн ИТХТ-дийн 2014 оны 50, 2015 оны 21, 35, 36 дугаар тогтоолоор нийт 9 нэр төрлийн хөрөнгө худалдахаар шийдвэрлэж орон нутгийн орлогод 14,245.9 мянга, 2016 онд аймгийн ИТХТ-дийн 2016 оны 14, 30 дугаар тогтоолоор 6 нэр төрлийн хөрөнгө худалдахаар шийдвэрлэж 8,500.0 мянга, 2017 онд аймгийн ИТХТ-дийн 2015 оны 35, 2017 оны 19 дүгээр тогтоолоор 3 нэр төрлийн хөрөнгө худалдахаар шийдвэрлэж 5,050.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод тус тус төвлөрүүлсэн байна.

Бүлэг 1

Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаанд мөрдөж буй хууль, журмын хэрэгжилт хангалтгүй, үр дүнг тооцож ажиллаагүй, холбогдох дүн шинжилгээ хийгээгүй байна.

1.1 Дуудлага худалдааг зохион байгуулахад мөрдөж буй хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулахдаа дуудлага худалдааг зохион байгуулах комиссыг аймгийн ИТХТ-дийн 2011 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчийн харилцааг зохицуулах” журам, 2017 оны “Дуудлага худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 23 дугаар тогтоолын дагуу томилж ажиллуулсан байна.

Орон нутгийн өмчит болон төсөвт байгууллагуудаас ирүүлсэн саналыг аймгийн ИТХТ-дийн хурлаар хэлэлцүүлэн орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах тухай тогтоол гарснаар дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилсон байна.

2015 онд 10 хөрөнгө, 2016 онд 6 хөрөнгө, 2017 онд 2 хөрөнгө нийт 18 хөрөнгө худалдах тогтоол гарсан бөгөөд 2015 онд 9 хөрөнгө, 2016 онд 6 хөрөнгө, 2017 онд 3 хөрөнгө худалдах нийт 5 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулагдан, 2015 онд 3 хөрөнгийн дуудлага худалдаа хүчингүй болж, дахин дуудлага худалдаа зохион байгуулжээ.

2015 онд “Талын илч” ОНӨҮГ-ын “БAM”-ын барилгыг худалдах дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2015 оны А/315 дугаар захирамжаар томилсон боловч мэргэжлийн байгууллагаар хөрөнгийн үнэлгээ хийгдээгүй шалтгаанаар дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй бөгөөд дуудлага худалдаа зохион байгуулах нөхцөл, шаардлага хангагдаагүй байхад дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг томилсон байна.

Харин 2017 онд уг хөрөнгөд “Ашид билгүүн” ХХК-иар үнэлгээ хийлгэж дуудлага худалдаа зохион байгуулсан боловч дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дахин томилоогүй, аймгийн Засаг даргын 2017 оны А/147 дугаар захирамжаар томилогдсон автомашины дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн үйл ажиллагаатай хамтатган зохион байгуулсан байна. /Хавсралт №1/

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.8, аймгийн ИТХТ-дийн 2017 оны 23 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5а дахь хэсгийг зөрчсөн байна.

Иймд эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах тухай бүрт аймгийн Засаг даргын захирамжаар дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг томилох, дуудлага худалдаа зохион байгуулах нөхцөл шаардлага бүрдсэн

тохиолдолд дуудлага худалдааг зохион байгуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Дуудлага худалдааг зохион байгуулах комисс нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон аймгийн ИТХТ-дийн 2011 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчийн харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу ажлын хэсгийн болон дуудлага худалдааны явцын хурлын тэмдэглэлийг хөтлөх талаарх үүргийг эрхзүйн актуудаар зохицуулсан байна.

Аудитын явцад 2015-2017 онд зохион байгуулагдсан 5 дуудлага худалдааны хурлын тэмдэглэлтэй танилцахад дараах зөрчлүүд илэрсэн ба 2015-2016 онд зөрчлүүд давтагдсан байна. /Хавсралт №2/

Тухайлбал:

- 2015 оны 2 удаагийн дуудлага худалдааны явцын хурлын тэмдэглэлд оролцогчдод пайз олгосон болон шийдвэр танилцуулсан тэмдэглэл үйлдээгүй, өмнөх явцын тэмдэглэлтэй дугаар давхацсан, 1 тэмдэглэл дугааргүй, үнийн дээд хязгаар тогтоогоогүй, хөтлөгч гарын үсэг зураагүй, шийдвэр танилцуулсан тэмдэглэл үйлдээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн ба “Талын илч” ОНӨҮГ-ын “БАН” барилгыг хэрхэн шийдвэрлэсэн тухай тэмдэглэл үйлдээгүй байна.
- 2016 оны 2 удаагийн дуудлага худалдааны явцын тэмдэглэлд байгууллага болон хөрөнгийн нэр, тоо хэмжээ, ажиглагчдын нэр, оролцогчдод пайз олгосон, дуудлага худалдаа явагдсан газрын талаар тэмдэглэл байхгүй
- 2017 оны дуудлага худалдааны явцын тэмдэглэлд ялагч, удаах оролцогчийн талаар тэмдэглэл үйлдээгүй байна.
- 2017 онд 2 хөрөнгийн дуудлага худалдааны явцын тэмдэглэлд ялагчийн нэрийг тусгаагүй, ялагч тодорхойгүй байхад гэрээ байгуулж хөрөнгийг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.5, 41.3.2, аймгийн ИТХТ-дийн 2017 оны 23 дугаар тогтоолын 5а дахь хэсгийг зөрчсөн байна.

Түүнчлэн дуудлага худалдааг зохион байгуулах явцын тэмдэглэлд орон нутгийн өмчийн төлөөлөгч нь дуудлага худалдааны нээлтэд холбогдох хууль тогтоомж, журмын заалт, эд хөрөнгө худалдах болон ажлын хэсэг томилсон шийдвэрийг танилцуулаагүй, хөтлөгч нь үнэ хаялцах хамгийн дээд болон доод хязгаарыг зарласан эсэх нь тодорхойгүй, тэмдэглэл хөтлөгч нь үнийн саналыг пайз өргөсөн дарааллаар үнэн зөв, бүрэн хөтөлж, явцын тэмдэглэлд бичээгүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн ИТХТ-дийн 2011 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчийн харилцааг зохицуулах журам”-д дуудлага худалдаанд оролцогчдын бүрдүүлэх материалын жагсаалтыг тодорхой заасан ба оролцогчдын эрх, үүргийг хангаж ажилласан байна.

Тухайлбал, иргэнд дуудлага худалдаанд оролцох, ялаагүй тохиолдолд дэнчинг буцаан авах зэрэг эрх хангагдсан ба үүргийн хувьд дуудлага худалдаанд оролцоход бүрдүүлэх материалыг бүрэн бүрдүүлсэн байна.

2015-2017 оны дуудлага худалдаанд оролцогчдын баримт материалын бүрдлийг хүснэгтээр харуулбал:

№	Худалдах хөрөнгийн нэр	Бүрдүүлэх баримт материалын нэр			Оролцсон хүний тоо
		Оролцох хүсэлт маягт	Иргэний үнэмлэх, хуулбар /УБГ/	Дэнчин тушаасан баримт	
1	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 26-09	+	+	+	6
2	Баянтал сумын ЗДТГ-ын “БАМ” барилга	+	+	+	9
3	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 25-43	+	+	+	5
4	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-48	+	+	+	6
5	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-46	+	+	+	5
6	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 32-03	+	+	+	7
7	Мотоцикл ГО 55-55	+	+	+	2
8	Автомашин Кантер	+	+	+	3
9	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-09	+	+	+	5
10	Ачааны автомашин Бонго ГСА 60-55	+	+	+	2
11	Суудлын автомашин УАЗ-22069 ГСА 01-04	+	+	+	5
12	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-05	+	+	+	9
13	Суудлын автомашин Аксент ГСА 62-52	+	+	+	10
14	Суудлын автомашин Соната ГСА 59-08	+	+	+	9
15	“Талын илч” ОНӨҮГ-ын цэцэрлэгийн “БАМ” барилга	+	+	+	5
16	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 34-56	+	+	+	17
17	Суудлын автомашин Тиана ГСА 35-59	+	+	+	22

Хүснэгтээс харахад: 2015-2017 онд давхардсан тоогоор нийт 127 иргэн дуудлага худалдаанд оролцож, бүрдүүлбэл зохих баримт материалыг бүрэн бүрдүүлсэн байна.

Дуудлага худалдаагаар худалдан борлуулах хөрөнгийн дэнчингийн хэмжээг аймгийн ИТХТ-дийн тогтоолоор баталсан бөгөөд 2017 онд дэнчингийн хэмжээг шинэчлэн баталсан байна.

2015-2017 онд дуудлага худалдааны дэнчинг тооцоход баримталж байгаа шийдвэрүүдийг хүснэгтээр харуулав.

№	Худалдах хөрөнгийн үнэ	Дэнчингийн хувь	Мөрдсөн хугацаа	Шийдвэрийн нэр
1	10.0 сая хүртэл	20%	2011.02.09 2017.05.30	Аймгийн ИТХТ-ийн 2011 оны 9 дүгээр тогтоол
2	10.0 сая дээш	10%		
3	5.0 сая хүртэл	25%	2017.05.30-аас одоог хүртэл	Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 23 дугаар тогтоол
4	5.0-10.0 сая хүртэл	20%		
5	10.0 сая дээш	10%		

Дуудлага худалдааны дэнчинг тооцохдоо 2011 оны 2 дугаар сараас аймгийн ИТХТ-дийн 2011 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн

этгээдэд өмчийн харилцааг зохицуулах журам”-д заасан хувийг мөрдөж байсан ба 2017 оны 5 дугаар сараас аймгийн ИТХТ-дийн 2017 оны 23 дугаар тогтоолоор дэнчингийн хувийг өөрчлөн тогтоож, дээрх журмыг хүчингүй болгосон байна.

2015-2017 онд зохион байгуулагдсан 5 удаагийн дуудлага худалдааны оролцогчдоос нийт 30,558.2 мянган төгрөгийн дэнчинг тооцож, төрийн сангийн Өмч хувьчлалын орлого дансанд бүрэн байршуулсан байна. Тухайлбал: 2015 онд 18,918.2 мянга, 2016 онд 5,640.0 мянга, 2017 онд 6,000.0 мянган төгрөгийн дэнчинг тус тус байршуулсан байна.

2016, 2017 онд дуудлага худалдааны дэнчингийн хувь хэмжээг үнэн зөв тооцож, холбогдох дансанд бүрэн байршуулсан байна. Харин 2015 онд дуудлага худалдааны дэнчингийн хэмжээг 5.0%-иар буюу 4,108.8 мянган төгрөгөөр илүү тооцож авсан нь оролцогчдын эрхийг зөрчих, эдийн засгийн хязгаарлагдмал байдлыг бий болгох эрсдэлтэй байна. /Хавсралт №3/

Энэ нь тухайн үед мөрдөгдөж байсан аймгийн ИТХТ-дийн 2011 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд дэнчинг тухайн цаг хугацаанд мөрдөгдөж буй тогтоолд заасан хувь хэмжээгээр үнэн зөв тооцож байх, дуудлага худалдаанд оролцогчдын эрхийг зөрчихгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2015-2017 онд зохион байгуулсан дуудлага худалдааны орлогоос нийт 27,853.9 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна. Үүнд:

- 2015 онд 8 төрлийн хөрөнгийг 14,303.9 мянга,
- 2016 онд 6 төрлийн хөрөнгийг 8,500.0 мянга,
- 2017 онд 3 төрлийн хөрөнгийг 5,050.0 мянган төгрөгөөр тус тус худалдан борлуулсан байна.

Дуудлага худалдааны орлогын бүрдүүлэлтийг гэрээний дүн, төрийн сангийн дансны хуулгатай тулган баталгаажуулахад 2015, 2016 онд хөрөнгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн ба 2017 онд 5,650.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн боловч орон нутгийн орлогод 5,050.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Энэ нь “Талын илч” ОНӨҮГ-ын “БАМ” барилгын 1,200.0 мянган төгрөгийн орлогын 50.0%-ийг дуудлага худалдааны зардал буюу “Залуус ТВ”-д дуудлага худалдааны зарын төлбөрт төлснөөр төсөвт 600.0 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

Аймгийн ИТХТ-дийн 2017 оны 23 дугаар тогтоолын 4-т “Төсөвт байгууллагын эд хөрөнгийн дуудлагын худалдаанаас орсон орлогыг 100% /дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр/ орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ” гэж заасан боловч дуудлага худалдааны зардлыг хэдэн хувиар тооцохыг тодорхой заагаагүй байна. Энэ нь орон нутгийн орлогыг тодорхой хэмжээгээр бууруулах учир дутагдалтай байна.

Иймд дуудлага худалдааны зардлыг оновчтой, зөв төлөвлөх, дуудлага худалдаанаас орох орлогын хэдэн хувиар зардлыг тооцох талаарх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож, тогтоолд нэмэлт оруулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2 Дуудлага худалдааны ялагчтай эрх зүйн чадамжгүй гэрээ байгуулсан бөгөөд дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааны үр дүнг тооцож ажиллаагүй, холбогдох дүн шинжилгээ хийгээгүй байна.

Аймгийн ОНӨГ нь 2015-2017 онд нийтдээ 5 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулж, 17 нэр төрлийн хөрөнгийг худалдан борлуулж, 17 ялагчтай худалдах худалдан авах гэрээг байгуулсан байна.

Дуудлага худалдааны ялагчтай байгуулсан гэрээг журмын дагуу байгуулсан эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. /Хавсралт №4/ Үүнд:

- 2015 онд иргэн Д.Түмэнжаргал, Н.Алтанхуяг, Д.Батжаргал, С.Лхагважав нартай байгуулсан худалдах, худалдан авах тухай гэрээнд дэнчингийн хэмжээг тусгаагүй, Ч.Наранболд, Д.Дондог нартай байгуулсан гэрээг дугаарлаагүй, худалдан авагч нарын гарын үсэг зурагдаагүй, мөн дээрх гэрээнүүдэд маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар тусгаагүй
- 2016 онд иргэн П.Наранмандах, Н.Алтанхуяг, Д.Батжаргал нартай байгуулсан гэрээнд дэнчингийн хэмжээг тусгаагүй, Ю.Баасанжавтай байгуулсан гэрээг дугаарлаагүй, Д.Батжаргалтай байгуулсан автомашин худалдах, худалдан авах тухай гэрээнд барилгын мэдээлэл оруулсан бол дээрх бүх гэрээнд маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар тусгаагүй
- 2017 онд Б.Мягмарсүрэнтэй байгуулсан гэрээнд хугацаа заагаагүй, суудлын автомашины дуудлага худалдааны явцын тэмдэглэлд ялагч Г.Бат-Ирээдүй 4,650.0 мянга, дараагийн оролцогч Ц.Тогоохүү 4,500.0 мянган төгрөгөөр худалдан авахаар тогтсон боловч гэрээ байгуулахаас татгалзсан бөгөөд дараагийн оролцогч Ю.Баасанжав 3,050.0 мянган төгрөгөөр худалдан авах саналыг ажлын хэсэгт ирүүлсэн байна. Ажлын хэсгийн хуралдаанаар дахин дуудлага худалдаа зарлахад нэмж зардал гарч, тухайн санал болгосон үнэд хүрэхгүй байх эрсдэлтэй гэж үзэн 3 дахь оролцогчид худалдах шийдвэр гаргасан байна.

Эдгээр зөрчил дутагдлаас харахад хүчингүй болсон дуудлага худалдааг дахин зарлаагүй, шууд гэрээ байгуулж хөрөнгийг худалдсан, гэрээг ор нэр төдий байгуулсан, гэрээнд тавигдах ерөнхий нөхцөл шаардлагыг хангаагүй, анхан шатны бүрдэл дутуу, хариуцлагын талаар тодорхой тусгаагүй, эрхзүйн чадамжгүй гэрээнүүдийг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.3.3, 43.3.7, 44 дүгээр зүйлийн 44.1, аймгийн ИТХТ-дийн 23 дугаар тогтоолын 5д, 5е дэх хэсгийг тус тус зөрчсөн байна.

Иймд дуудлага худалдааны ялагчтай байгуулсан гэрээг дугаарлах, хугацааг тодорхой заах, оролцогч талуудын эрх, үүрэг, дэнчингийн хэмжээ, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар тусгах, гэрээнд хяналт тавих, ялагч болон удаах оролцогч төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд дуудлага худалдаа дахин явуулах зэрэг дуудлага худалдааны ялагчтай гэрээнд тавигдах ерөнхий нөхцөл шаардлагыг хангасан, эрх зүйн чадамж бүхий гэрээг байгуулан ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааг аймгийн Орон нутгийн өмчийн алба хариуцан зохион байгуулж ирсэн бөгөөд Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор

худалдах, худалдан авах гэрээний загвар батлагдсан боловч 2015-2017 онд зохион байгуулсан дуудлага худалдааны ялагчтай байгуулсан гэрээнд дээрх загварыг мөрдөж ажиллаагүй, уг загвараар гэрээг байгуулаагүй байна. Тухайлбал, 2015-2016 онд байгуулсан 14 гэрээнд дэнчингийн хэмжээ, оролцогч талуудын эрх, үүрэг, гэрээний үүргийн талаар үүссэн маргааныг хянан шийдвэрлэх тухай заалт тусгагдаагүй байна.

2017 онд аймгийн ИТХТ-дийн 2017 оны 23 дугаар тогтоолоор дуудлага худалдааны ялагчтай байгуулах “Худалдах, худалдан авах гэрээ”-ний загварыг шинэчилсэн ба оролцогч талуудын эрх, үүрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухай заалтыг нэмж оруулсан байна.

2015, 2016 онд байгуулсан 14 гэрээнд оролцогч талуудын эрх, үүрэг тусгагдаагүй тул хэрэгжилтийг тооцох боломжгүй байна.

Харин 2017 онд Д.Батжаргалтай байгуулсан “Талын илч” ОНӨҮГ-ын “БAM” барилга худалдах, худалдан авах гэрээнд заасан эрх, үүрэг бүрэн хэрэгжээгүй байна.

Энэ нь гэрээний 4.2.5-д “худалдан авагч нь тухайн барилгыг буулган, газар чөлөөлүүлэхээр барилгын материалыг худалдсан тул материалыг бүрэн авч дууссаны дараа туурь хогийг цэвэрлэн, газрыг нөхөн сэргээж, тэгшлэн сумын байгаль орчны асуудал хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөх үүрэгтэй” гэж заасан боловч худалдан авагч тал барилгыг буулгаагүйгээс үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй тул одоог хүртэл хөрөнгийг хүлээлцээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.3.3, 43.3.7, 44 дүгээр зүйлийн 44.1, аймгийн ИТХТ-дийн 23 дугаар тогтоолын 5д, 5е дэх хэсгийг тус тус зөрчсөн байна.

Иймд гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй Д.Батжаргалтай байгуулсан “Талын илч” ОНӨҮГ-ын “БAM” барилга худалдах, худалдан авах гэрээнд заасан эрх, үүргийн хэрэгжилтийг хангуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2015-2017 онд дуудлага худалдааны ялагчтай хөрөнгө худалдах, худалдан авах тухай нийт 17 гэрээ байгуулагдсан бөгөөд гэрээнд зааснаар 16 худалдан авагчид орлогыг бүрэн төвлөрүүлсний дараа хөрөнгийг хүлээлгэн өгсөн байна.

2015-2017 онд дуудлага худалдаагаар худалдсан хөрөнгийг хүлээлгэн өгсөн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3					
№	Хөрөнгийн нэр	Худалдсан үнэ	Гэрээ байгуулсан огноо	Төлсөн огноо	Хүлээлцсэн акт огноо
1	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 26-09	1,700.0	2015.07.24	2015.07.24	2015.07.24
2	Баянтал сумын ЗДТГ-ын “БAM” барилга	2,285.0	2015.08.07	2015.07.30	2015.08.07
3	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 25-43	1,000.0	2015.07.24	2015.07.24	2015.07.24
4	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-48	2,700.0	2015.12.02	2015.12.02	2015.12.03
5	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-46	2,700.0	2015.12.02	2015.12.02	2015.12.02
6	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 32-03	2,700.0	2015.12.04	2015.12.03	2015.12.03
7	Мотоцикл ГО 55-55	250.0	2015.11.10	2015.11.11	Акт байхгүй
8	Автомашин Кантер	968.9	2015.11.10	2015.11.11	Акт байхгүй

9	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-09	2,100.0	2016.04.07	2016.04.21	2016.04.21
10	Ачааны автомашин Бонго ГСА 60-55	700.0	2016.04.07	2016.04.21	2016.04.21
11	Суудлын автомашин УАЗ-22069 ГСА 01-04	2,000.0	2016.04.05	2016.04.05	2016.04.05
12	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-05	1,200.0	2016.09.26	2016.09.27	Акт байхгүй
13	Суудлын автомашин Аксент ГСА 62-52	1,200.0	2016.09.26	2016.09.27	Акт байхгүй
14	Суудлын автомашин Соната ГСА 59-08	1,300.0	2016.09.26	2016.09.27	2016.09.27
15	“Талын илч” ОНӨҮГ-ын цэцэрлэгийн “БAM” барилга	1,200.0	2017.06.29	2017.06.30	Хүлээлгэж өгөөгүй
16	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 34-56	3,050.0	2017.07.27	2017.07.27	2017.07.27
17	Суудлын автомашин Тиана ГСА 35-59	800.0	Гэрээ хугацаагүй	2017.07.27	2017.07.03

Хүснэгтээс харахад: 4,985.0 мянган төгрөгийн 2 хөрөнгийг гэрээ байгуулахаас өмнө төлбөрийг төлсөн, 4,818.9 мянган төгрөгийн 5 хөрөнгийг хүлээлцсэн акт үйлдээгүй, 800.0 мянган төгрөгийн 1 хөрөнгийг төлбөр төлөөгүй байхад хүлээлгэн өгсөн, гэрээний хугацааг тодорхой заагаагүй, хөрөнгийг хүлээн авснаас хойш 23 хоногийн дараа төлбөрийг төлсөн зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4, аймгийн ИТХТ-дийн 23 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5е дэх хэсгийг тус тус зөрчсөн байна.

Иймд гэрээнд заасны дагуу орлогыг бүрэн төвлөрүүлсний дараа худалдан авагчид хөрөнгийг хүлээлгэн өгөх, хөрөнгө хүлээлгэн өгсөн акт үйлдэх, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Орон нутгийн өмчийн алба нь аймгийн ИТХ-ын бүтцэд хамааран үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор 2016 оны 11 дүгээр сарын 14-ны өдрөөс “Орон нутгийн өмчийн газар” нэртэйгээр шинээр зохион байгуулагдсан байна. Тус газар нь бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэнээр АИТХ-аас гаргасан өмч хөрөнгийн холбоотой тогтоолын биелэлт гарган хүргүүлж ирсэн байна.

2017 онд хагас, бүтэн жилээр аймгийн ИТХТ-дийн 2017 оны А/19, А/35 дугаар тогтоолын “Дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, дуудлага худалдааг хууль, тогтоомж журмын дагуу зохион байгуулах” гэсэн заалтын хэрэгжилтийг гарган хүргүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн алба нь 2015-2017 онд орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааны үр дүнг тооцож ажиллаагүй, холбогдох дүн шинжилгээ хийгээгүй байна.

Бүлэг 2

Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаанд хяналт шалгалт огт хийгдээгүй байна.

2.1 Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод мэдээлэх үйл явц өргөн цар хүрээг хамруулаагүй байна.

Аймгийн хэмжээнд дуудлага худалдаагаар хөрөнгө худалдан борлуулах үйл ажиллагааны зар мэдээллийг 2015 онд аймгийн Холбооны газар, 2016 оноос орон нутгийн телевиз /Залуус ТВ/, байгууллагын вэбсайт /www.haaa.gs.gov.mn/, ОНӨГ-ын мэдээллийн самбарт тус тус байршуулсан байна.

Дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээний агуулга хуульд нийцсэн эсэх, хэрхэн байршуулсан талаар тулган баталгаажуулалт хийхэд 2015, 2016 онд явагдах дуудлага худалдааны зар мэдээлэлд дуудлага худалдааны ялагчтай байгуулах гэрээний ерөнхий нөхцлийн талаар дурьдаагүй зөрчил илэрсэн бөгөөд 2017 оны зар мэдээлэлд дээрх агуулгыг тусгасан байна.

Харин 2015, 2016 онд аймгийн Холбооны газраас гадна АИТХ-ын дэргэд үйл ажиллагаа явуулж байснаас зар мэдээллийг АИТХ-ын facebook хаягаар олон нийтэд мэдээлдэг байсан гэх боловч цахим архив үүсгээгүйгээс 2016 оны 11 дүгээр сарын 23-наас өмнөх бүх мэдээлэл устсан нь хэдэн удаа, ямар байдлаар зар мэдээлэл хүргэсэн талаар тодорхойгүй байгаа нь оролцогчдод хүртээмжтэй байдлаар түгээсэн эсэх тодорхойгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааны зар мэдээлэлд хуульд заасан мэдээллүүдийг бүрэн тусгах, мэдээлэх нөхцлийг хүртээмжтэй, оновчтой байдлаар сонгох, өргөн цар хүрээг хамруулах, томоохон худалдааны төвүүдийн мэдээллийн самбарт байршуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагааны зарыг дуудлага худалдаа явагдахаас 30 хоногийн өмнө мэдээлэхээр хуульчлагдсан ба 2016 оны 1, 2017 оны 1 дуудлага худалдааны зар мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Харин 2015 оны 2, 2016 оны 1 дуудлага худалдааны зарыг хугацаанд нь мэдээлсэн эсэх тодорхойгүй, холбогдох нотлох баримтыг архивлаагүй байна.

Иймд дуудлага худалдааны зар мэдээллийг хугацаанд нь түгээх, зар мэдээллийн эх хувийг архивлах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.2 Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаанд аймгийн ИТХ болон бусад байгууллагуудаас хяналт шалгалт огт хийгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2015 онд 9, 2016 онд 6, 2017 онд 3 төрлийн хөрөнгө худалдан борлуулах дуудлага худалдаа зохион байгуулагдсан ба 2015 онд 2, 2016 онд 2, 2017 онд 1 удаа ажлын хэсэг томилогдсон байна.

2015-2017 онд зохион байгуулагдсан хөрөнгийн дуудлага худалдаатай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Дуудлага худалдаа зохион байгуулах бүх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орон нутгийн өмчийн төлөөлөгч оролцсон ба жил бүрийн дуудлага худалдааны явцын тэмдэглэлд зөрчлүүд давтагдсан байна. Тухайлбал, 2015 оны 9 хөрөнгийн дуудлага худалдааны явцын тэмдэглэлд 15, 2016 оны 6 хөрөнгийн дуудлага худалдааны явцын тэмдэглэлд 13, 2017 оны 3 хөрөнгийн дуудлага худалдааны явцын тэмдэглэлд 2 зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3.1, 41.3.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- 2015 онд 2 мотоцикл, 1 автомашин худалдах дуудлага худалдаа хүчингүй болж, аймгийн ИТХТ-дийн 2015 оны 36 дугаар тогтоолоор худалдах доод үнийг 50.0%-иар бууруулан дахин дуудлага худалдаа зарласан байна. Дахин дуудлага худалдаагаар 1 мотоцикл худалдах дуудлага худалдаа хүчингүй болсон бөгөөд уг хөрөнгөд дахин дуудлага худалдаа зарлаагүй, акталж данснаас хассан байна.

Энэ нь тухайн үед мөрдөгдөж байсан аймгийн ИТХТ-дийн 2011 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөгч нь дуудлага худалдааг хуульд заасан журмаар явуулж байгаа эсэх болон тэмдэглэл хөтлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, дуудлага худалдааны явцын тэмдэглэл үнэн зөв, бүрэн хөтлөгдсөн эсэхийг хянах, дуудлага худалдаагаар худалдагдаагүй хөрөнгөд хуулийн дагуу дахин дуудлага худалдааг зохион байгуулах үүрэгтэй боловч дуудлага худалдааны зохион байгуулалтад хяналт тавьж ажиллаагүй, жил бүр зөрчлийг давтан гаргасан орон нутгийн өмчийн мэргэжилтэнд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2015-2017 онд зохион байгуулагдсан дуудлага худалдааны үр дүн, тайланг АИТХ-аар огт хэлэлцүүлээгүй бөгөөд 2017 оноос тогтоолын хэрэгжилтийг гарган хүргүүлж эхэлсэн байна.

2015-2017 онд зохион байгуулагдсан дуудлага худалдааны үр дүн, шийдвэрийн хэрэгжилтэд АИТХ болон бусад байгууллагуудаас хяналт шалгалт огт хийгдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2, аймгийн ИТХТ-ийн 2017 оны 23 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5а, 5д, 7 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Иймд АИТХ нь тэргүүлэгчид, аймгийн ЗД-аас орон нутгийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайланг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгч байх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, аймгийн ЗД нь дуудлага худалдаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх, гэрээний үүргийн биелэлт, дуудлага худалдааны орлого орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нийцлийн аудитаар нийт 18,362.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1,200.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 9 зөвлөмж хүргүүллээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Дуудлага худалдааг зохион байгуулахад мөрдөж буй хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байна.
2. АИТХТ-дийн тогтоолоор баталсан дэнчингийн хувь хэмжээг илүү тооцсон, дуудлага худалдаанаас орох орлогын хэдэн хувиар зардлыг тооцох талаарх эрх зүйн зохицуулалт тодорхойгүйгээс дуудлага худалдааны орлогыг бууруулан төсөвт төвлөрүүлсэн байна.
3. Дуудлага худалдааны ялагчтай гэрээнд тавигдах ерөнхий нөхцөл шаардлагыг хангаагүй, анхан шатны бүрдэл дутуу, хариуцлагын талаар тодорхой тусгаагүй, эрхзүйн чадамжгүй гэрээг байгуулсан байна.
4. Дуудлага худалдаанд оролцогч талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
5. Дуудлагын худалдааны зар мэдээлэлд хуульд заасан мэдээллүүдийг тусгаагүй, өргөн цар хүрээг хамруулах арга хэрэгслийг сонгож, ил тод мэдээлээгүй байна.
6. ОНӨГ-ын төлөөлөгч нь дуудлага худалдааны явцад хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.
7. Дуудлага худалдааны үр дүнг тайлагнаагүй, АИТХ-аар хэлэлцүүлээгүй, АИТХ болон бусад байгууллагуудаас хяналт шалгалт огт хийгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-д:

1. Аймгийн ИТХТ-дийн 2017 оны 23 дугаартай “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүн, тайланг ИТХТ-дийн хурлаар хэлэлцэх
2. Аймгийн ИТХТ-дийн 2017 оны 23 дугаартай “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд дуудлагын худалдааны зардлыг орлогын хэдэн хувиар тооцох тухай заалт нэмж оруулах

Аймгийн Засаг даргад:

1. Засаг даргын захирамжаар томилогдсон дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсэг дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу явуулсан эсэх, гэрээний үүргийн биелэлт, дуудлага худалдааны орлого орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах

Аймгийн ОНӨГ-т

1. Дуудлага худалдаа зохион байгуулах тухай бүрт ЗД-ын захирамжаар ажлын хэсэг томилуулах, дуудлага худалдаа зохион байгуулах нөхцөл шаардлага бүрдсэн тохиолдолд дуудлага худалдааг зохион байгуулах
2. Дуудлага худалдааны явцын болон хурлын тэмдэглэлийг журмын дагуу үнэн зөв бүрэн хөтлөх, тухай бүрт хяналт тавих
3. Дуудлага худалдааны дэнчингийн хувь хэмжээг үнэн зөв тооцох
4. Дуудлага худалдааны ялагчтай байгуулах гэрээг дугаарлах, хугацааг тодорхой заах, гэрээнд хуульд заасан мэдээллүүдийг тусгах, оролцогчдын эрх, үүргийг тодорхой тусгах
5. Дуудлага худалдааны орлогыг бүрэн төвлөрүүлсний дараа худалдан авагчид хөрөнгийг хүлээлгэн өгөх, тухай бүрт хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэх
6. Дуудлага худалдааны зар мэдээнд хуульд заасан мэдээллүүдийг заавал тусгах, өргөн цар хүрээг хамарч, оновчтой мэдээллийг хүргэх арга хэрэгслийг сонгож зар мэдээг явуулах
7. Дуудлага худалдааны үр дүнг тооцох, тайланг гаргах, АИТХ-аар хэлэлцүүлэх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Аймгийн ОНӨГ-аас ирүүлсэн санал:

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

42017 Чойр, Говьсүмбэр аймаг,
Утас/Факс: 70543033, E-mail: munkh.hudaldan@gmail.mn

2018.08.28 № 125
танай 2018.08.28-ны № 165 -Т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдан борлуулах үйл ажиллагаа, үр дүн"-д хийгдсэн нийцлийн аудитын зөвлөмж, дүгнэлттэй танилцлаа.

Зөвлөмж саналыг хүлээн авч, цаашид дуудлагын худалдаанд мөрдөгдөж буй хууль, журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллахаа үүгээр илэрхийлж байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б. Ахтүрээг
Саналыг танилцан
орүүлж, тайлбар
хотолон батлав.
мундаг
2018/08/28

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ИРҮҮЛСЭН ТАЙЛБАР

Аймгийн ОНӨГ-аас ирүүлсэн албан бичигт тайлантай холбоотой санал, тайлбар байхгүй тул тайланд өөрчлөлт ороогүй болно.

№	Худалдах хөрөнгийн нэр	Худалдах шийдвэр	Ажлын хэсгийг томилсон шийдвэр	Дуудлагын худалдаа хүчинтэй болсон эсэх
2015 он				
1	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 26-09	ИТХТ-ийн 2014.12.22 өдрийн 50 дугаар тогтоол	Аймгийн ЗД-ын 2015.06.26 өдрийн А/195 дугаар захирамж	Тийм
2	Баянтал сумын ЗДТГ-ын “БАМ” барилга			Тийм
3	Мотоцикл ГО 55-55	ИТХТ-ийн 2015.06.22 өдрийн 21 дүгээр тогтоол		Үгүй
4	Мотоцикл ГО 76-74			Үгүй
5	Автомашин Кантер			Үгүй
6	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 25-43			Тийм
7	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-48	ИТХТ-ийн 2015.10.23 өдрийн 35 дугаар тогтоол	Аймгийн ЗД-ын 2015.11.03 өдрийн А/315 дугаар захирамж	Тийм
8	“Талын илч” ОНӨҮГ-ын цэцэрлэгийн “БАМ” барилга			Үгүй
9	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-46			Тийм
10	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 32-03			Тийм
11	Мотоцикл ГО 55-55			Тийм
12	Мотоцикл ГО 76-74			Үгүй
13	Автомашин Кантер			Тийм
2016 он				
1	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-09	ИТХТ-ийн 2016.02.24 өдрийн 14 дүгээр тогтоол	Аймгийн ЗД-ын 2016.03.04 өдрийн А/79 дугаар захирамж	Тийм
2	Ачааны автомашин Бонго ГСА 60-55			Тийм
3	Суудлын автомашин УАЗ-22069 ГСА 01-04			Тийм
4	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-05	ИТХТ-ийн 2016.08.16 өдрийн 30 дугаар тогтоол	Аймгийн ЗД-ын 2016.08.19 өдрийн А/228 дугаар захирамж	Тийм
5	Суудлын автомашин Аксент ГСА 62-52			Тийм
6	Суудлын автомашин Соната ГСА 59-08			Тийм
2017 он				
1	“Талын илч” ОНӨҮГ-ын цэцэрлэгийн “БАМ” барилга	ИТХТ-ийн 2015.10.23 өдрийн 35 дугаар тогтоол	Комисс томилоогүй	Тийм
2	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 34-56	ИТХТ-ийн 2017.05.01 өдрийн 19 дугаар тогтоол	Аймгийн ЗД-ын 2017.05.17 өдрийн А/147 дугаар захирамж	Тийм
3	Суудлын автомашин Тиана ГСА 35-59			Тийм

№	Худалдах хөрөнгийн нэр	Худалдах үнэ	Дэнчин тооцсон хувь	Дэнчин тооцох хувь	Зөрүү
2015 он					
1	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 26-09	1,500.0	25% буюу 375.0	20% буюу 300.0	5% буюу 75.0
2	Баянтал сумын ЗДТГ-ын "БAM" барилга	2,085.0	25% буюу 521.3	20% буюу 417.0	5% буюу 104.3
3	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 25-43	800.0	25% буюу 200.0	20% буюу 160.0	5% буюу 40.0
4	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-48	2,500.0	25% буюу 625.0	20% буюу 500.0	5% буюу 125.0
5	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-46	2,500.0	25% буюу 625.0	20% буюу 500.0	5% буюу 125.0
6	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 32-03	2,500.0	25% буюу 625.0	20% буюу 500.0	5% буюу 125.0
7	Мотоцикл ГО 55-55	150.0	25% буюу 37.5	20% буюу 30.0	5% буюу 7.5
8	Автомашин Кантер	868.95	25% буюу 217.3	20% буюу 173.8	5% буюу 43.5

№	Худалдах хөрөнгийн нэр	Дуудлага худалдаа зохион байгуулах комисс томилсон шийдвэр	Хурлын тэмдэглэл
1	Суудлын автомашин УАЗ-31512	АЗД-ын 2015.06.26 өдрийн А/195 дугаар захирамж	Оролцогчдод пайз олгосон болон шийдвэр танилцуулсан тэмдэглэл үйлдээгүй
2	Баянтал сумын ЗДТГ-ын “БАМ” барилга		Хөтлөгч гарын үсэг зураагүй, шийдвэр танилцуулсан тэмдэглэл үйлдээгүй
3	Мотоцикл ГО 55-55		Дуудлага худалдаа хүчингүй болсон
4	Мотоцикл ГО 76-74		Дуудлага худалдаа хүчингүй болсон
5	Автомашин Кантер		Дуудлага худалдаа хүчингүй болсон
6	Суудлын автомашин УАЗ-31512		Оролцогчдод пайз олгосон болон шийдвэр танилцуулсан тэмдэглэл үйлдээгүй
7	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-48	АЗД-ын 2015.11.03 өдрийн А/315 дугаар захирамж	Оролцогчдод пайз олгосон тэмдэглэл байхгүй, дугааргүй
8	“Талын илч” ОНӨҮГ-ын цэцэрлэгийн “БАМ” барилга		Тэмдэглэл байхгүй
9	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-46		Оролцогчдод пайз олгосон тэмдэглэл байхгүй
10	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 32-03		Оролцогчдод пайз олгосон тэмдэглэл байхгүй
11	Мотоцикл ГО 55-55		Оролцогчдод пайз олгосон болон шийдвэр танилцуулсан тэмдэглэл үйлдээгүй, дээд хязгаар тогтоогоогүй
12	Мотоцикл ГО 76-74		Дуудлага худалдаа хүчингүй болсон
13	Автомашин Кантер		Өмнөх тэмдэглэлтэй дугаар давхацсан, дээд хязгаар тогтоогоогүй
2016 он			
1	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-09	АЗД-ын 2016.03.04 өдрийн А/79 дугаар захирамж	Байгууллага, хөрөнгийн нэр, тоо хэмжээ, ажиглагчдын нэрс, оролцогчдод пайз олгосон тэмдэглэл байхгүй
2	Ачааны автомашин Бонго ГСА 60-55		Оролцогчдод пайз олгосон болон ажиглагчдын нэрс байхгүй
3	Суудлын автомашин УАЗ-22069 ГСА 01-04		Байгууллага, хөрөнгийн нэр, ажиглагчдын нэрс байхгүй
4	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-05	АЗД-ын 2016.08.19 өдрийн А/228 дугаар захирамж	Байгууллага, хөрөнгийн нэр, ажиглагчдын нэрс, оролцогчдод пайз олгосон тэмдэглэл байхгүй
5	Суудлын автомашин Аксент ГСА 62-52		Байгууллага, хөрөнгийн нэр, ажиглагчдын нэрс байхгүй
6	Суудлын автомашин Соната ГСА 59-08		Байгууллага, хөрөнгийн нэр, ажиглагчдын нэрс, дуудлага худалдаа болсон газрын нэр байхгүй
2017 он			
1	“Талын илч” ОНӨҮГ-ын цэцэрлэгийн “БАМ” барилга	Комисс томилоогүй	-
2	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 34-56	АЗД-ын 2017.05.17 өдрийн А/147 дугаар захирамж	Ялагч, удаах оролцогчийн талаар мэдээлэл байхгүй
3	Суудлын автомашин Тиана ГСА 35-59		Ялагч, удаах оролцогчийн талаар мэдээлэл байхгүй

№	Худалдсан хөрөнгийн нэр	Ялагчийн нэр	Дуудлага худалдаа зохион байгуулсан он сар, өдөр	Гэрээ байгуулсан он сар өдөр, дугаар	Гэрээ хууль, журманд нийцсэн эсэх
1	Суудлын автомашин УАЗ-31512	Д.Түмэнжаргал	2015.07.24	2015.07.24	Дэнчин, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
2	Баянтал сумын ЗДТГ-ын "БАМ" барилга	Н.Алтанхуяг	2015.07.24	2015.08.07 №3	Дэнчин, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
3	Суудлын автомашин УАЗ-31512	Д.Батжаргал	2015.07.24	2015.07.24	Дэнчин, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
4	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-48	Ч.Наранболд	2015.12.02	2015.12.02	Дугааргүй, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
5	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 31-46	Д.Дондог	2015.12.02	2015.12.02 №2	Маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
6	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 32-03	Д.Дондог	2015.12.02	2015.12.04	Дугааргүй, худалдан авагч гарын үсэг зураагүй
7	Мотоцикл ГО 55-55	С.Лхагважав	2015.11.10	2015.11.10 №11/06	Дэнчин, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
8	Автомашин Кантер	С.Лхагважав	2015.11.10	2015.11.10 №1	Дэнчин, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
9	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-09	П.Наранмандах	2016.04.04	2016.04.07 №3	Маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
10	Ачааны автомашин Бонго ГСА 60-55	Н.Алтанхуяг	2016.04.04	2016.04.07 №1	Маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
11	Суудлын автомашин УАЗ-22069 ГСА 01-04	Д.Батжаргал	2016.04.04	2016.04.05 №2	Маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
12	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 01-05	Г.Баасанжав	2016.09.26	2016.09.26	Дугааргүй, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
13	Суудлын автомашин Аксент ГСА 62-52	Г.Баасанжав	2016.09.26	2016.09.26	Дугааргүй, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
14	Суудлын автомашин Соната ГСА 59-08	Д.Батжаргал	2016.09.26	2016.09.26	Барилгын мэдээлэл оруулсан, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар оруулаагүй
15	"Талын илч" ОНӨҮГ-ын цэцэрлэгийн "БАМ" барилга	Д.Батжаргал	2017.06.22	2017.06.29 №1	-
16	Суудлын автомашин УАЗ-31512 ГСА 34-56	Ю.Баасанжав	2017.06.22	2017.07.27 №3	-
17	Суудлын автомашин Тиана ГСА 35-59	Б.Мягмарсүрэн	2017.06.22	№2	Он сар өдөр байхгүй

